

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-НИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Монголын төмөр зам” /МТЗ/ ТӨХК-ний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 тоот тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“МТЗ” ТӨХК-ний гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **72.9** хувьтай байна.

2.1. “МТЗ” ТӨХК-ний 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 45 арга хэмжээ тусгагдсан бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
45	72.9	20	7	4	-	12	2	-

1.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг суурь түвшинтэй нь харьцуулан /томьёоны дагуу/ гаргасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)					
		100	90	70	50	30	0
2	0	-	-	-	-	-	2

1.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Эрхзүйн актын нэр	Нийт заалт	Хэрэгжилт (хувиар)	Үүнээс (хувиар)				Хугацаа болоогүй
			100	70	30	0	
Улсын Их хурлын тогтоол	1	70.0	-	1	-	-	-
Засгийн газрын тогтоол	7	41.4	1	1	4	1	-

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	4	75.0	3	-	-	1	-
Засгийн газрын албан даалгавар	2	50.0	1	-	-	1	-
Дүн	14	54.3	5	2	4	3	-

1.4. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				
		100	70	30	0	Хугацаа болоогүй
12	85.8	9	1	2	-	-

1.5. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Хэрэгжилтийн дундаж хувь	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Хугацаа болоогүй (төрийн тоо)	Оруулах мэдээлэлгүй
				100	90	70	50	30	0		
1	Төсөв, гүйцэтгэл	14	100.0	6	-	-	-	-	-	-	8
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	100.0	4	-	-	-	-	-	-	2
3	Бусад	8	100.0	7	-	-	-	-	-	-	1
Дүн		28	100.0	17	-	-	-	-	-	-	11

1.6. Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс /хувиар/				
				100	70	30	0	Хамааралгүй
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратег, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	81.2	3	5	-	-	2
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	90.0	4	2	-	-	-
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх	15	90.7	13	-	2	-	-

	мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	100.0	1	-	-	-	1
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	100.0	10	-	-	-	3
Дүн		46	91.2	31	7	2	-	6

Гурав. Дүгнэлт

I. Төлөвлөлтийн байдал

1. “МТЗ” ТӨХК нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөтэй уялдуулан улирал бүрээр хүрэх боломжтойгоор БТГ, ХШҮДАГ-аар гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянуулан батлуулсан байна.

2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн ч дээрх хуулийн хэрэгжилтэд нийцүүлэн тухайн жилд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр батлуулахдаа өөрийн байгууллагын хариуцан хэрэгжүүлж байгаа төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэх талаар зөв төлөвлөн тусгаагүй байна.

II. Хэрэгжилтийн байдал:

1. Тус компани нь 2024 онд үйл ажиллагаандаа нийт 147 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласнаас 100 хувийн үнэлгээтэй 82, 90 хувийн хэрэгжилттэй 7, 70 хувийн хэрэгжилттэй 14, 30 хувийн хэрэгжилттэй 20, тасарсан буюу хэрэгжүүлээгүй 7, хамааралгүй 6, оруулах мэдээлэлгүй 11 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар **80.1** хувьтай байна.

2. Тус компани нь Цогтцэций-Зүүнбаян, Цогтцэций-Зүүнбаян, Төмөртэй-Хандгайт чиглэлийн төмөр замаар 3.007.408,9 тонн ачаа тээвэрлэсэн байна.

3. “МТЗ” ТӨХК-ийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 30.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, орлого нэмэгдэж, зардлыг хэмнэн ажилласан.

4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам төслийн бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн.

5. Тус компанийн шилэн дансны хөтлөлтийг хариуцан хэрэгжүүлж, хянах ажил 2024 онд бүрэн хэрэгжиж,

6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгон хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлсэн хэдий ч байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй хэвээр байна.

7. Тус байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй хэвээр байна. Үүнд:

- “МТЗ” ТӨХК-ний 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжээгүй, хэрэгжилт хангалтгүй болон удаашралтай байгаа цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах гэрээ болон төрийн эрх бүхий байгууллагатай концессын гэрээний байгуулах, Шивээхүрэн-Шинэжинст чиглэлийн дараагийн 200 км төмөр замын ТЭЗҮ зураг төслийг боловсруулах, Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын эхлэлийн Шивээхүрэн Нарийнсухайт чиглэлийн төмөр замыг эхлүүлэх хэрэгжилтийг сайжруулахад анхаарах;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход анхаарч байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

- Бүрэн хэрэгжсэн ч тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, хоёр мянган тэмдэгтэд багтаан ажлын үйл, явц тоочилгүй, огноог тодорхой дурдан, зөв бичгийн дүрмийн алдаагүй тайлагнаж хэвших;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ болох Ханги-Мандал боомтын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1,255 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих ажлын гүйцэтгэлийг зорилтот түвшинд хүргэн ажиллаж, Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр замын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрлүүдийг авах, барилгын ажлыг эхлүүлэх чиглэлээр “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААҮГ-тай хамтран ажиллаж, төслүүдийг эхлүүлэх;
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчилгүй санал, дүгнэлт авч, алдаа, дутагдал гаргахгүй байхад анхаарч удирдлагын хяналтыг сайжруулах;
3. Улаанбаатар-Хархорин чиглэлийн хурдны төмөр замын Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажилд бодит ахиц гарган ажиллах;
4. “Монгол-Тяньжины тээвэр логистикийн төсөл”-ийн ажлыг эрчимжүүлэн төслийг 2025 онд багтаан эхлүүлэх;
5. Хөрөнгө санхүүжилт шаардагдахгүй хэрэгжүүлэх боломжтой тариф батлуулах, салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнг мэдээллийн олон сувгийг ашиглан олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зорилтот түвшинд хүргэн ажиллаж, суурь бүтцийн тариф батлуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайлагнах зэрэг ажлыг яаралтай дуусгах;
6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг тогтмол хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулах;
7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнахдаа хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд, заасан тэмдэгтэд багтаан, ажлын явц тоочилгүй, бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, тодорхой ахиц гаргах;
8. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа, хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, зөв бичгийн алдаагүй, хоёр мянган тэмдэгтэд багтаан, үр дүнг тайлагнаж хэвших;
9. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө бүрэн тусгаж, төлөвлөлтийг зөв тодорхойлон, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР